



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/557

Булган сум

Ажил хүлээлцэх ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 83.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирлын ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)  
М.Лхагваням (“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн менежер)  
Б.Үүрцайх (“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн нягтлан бодогч)

2. “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирлын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүлээлцүүлэхийг ажлын хэсэг (Г.Давааням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010751